# СҮХБААТАР АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
# 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТ

2024.06.17 Баруун-Урт сум

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Стратегийн зорилго №1 ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ | | | | | | | |
| Стратегийн зорилт №1 Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмжийн стандартын түвшин, хангалтыг дээшлүүлж, гамшгийн үеийн харилцаа холбоог сайжруулах. | | | | | | | |
| 1.1.1 | Монгол Улсын Шадар сайд, Улсын Онцгой Комиссын шийдвэрийн дагуу хүчтэй газар хөдлөлтөөс үүсэх хөрсний чичирхийллийн хэмжээг бичигч багажийг худалдан авч сумдын нутаг дэвсгэрт суурилуулах асуудлаар Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн хүрээлэнтэй хамтран ажиллах | Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаар 30,0 сая төгрөг | 3,5 баллаас дээш газар хөдлөлтийг мэдээллийг дамжуулах | Сүхбаатар аймгийн хэмжээнд газар хөдлөлтийн чичирхийллийн хэмжээг бичигч багаж байхгүй | Эрдэнэцагаан, Баруун-Урт, Түмэнцогт сумдад газар хөдлөлтийн чичирхийллийн хэмжээг бичигч багаж суурилуулсан байх | Аймгийн хэмжээнд 2023-2024 оны өвөлжилт, хаваржилт хүндэрч төмөр буюу мөсөн зудын хэмжээнд хүрч нийт малын 44.8 хувь нь хорогдож, аймгийн Онцгой Комиссоос зудын гамшигтай тэмцэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд гамшгаас хамгаалах сан болон Засаг даргын нөөц сан зарцуулагдаж дууссан. Үүнтэй холбогдуулан МУШС-тай байгуулсан гэрээ, ГЭБОНЗ-ын төлөвлөгөөнд тусгагдсан газар хөдлөлтийн чичирхийллийн хэмжээг бичигч багаж худалдан авах зардлыг шийдвэрлүүлэхээр аймгийн Засаг даргад ОБГ-ын даргын 2024 оны 32/369 тоот албан бичиг хүргүүлээд байна. | - |
| 1.1.2 | Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд гамшиг, осол болзошгүй эрсдэлээс сэргийлэх зарлан мэдээллийг сайжруулах зорилготой 3 ширхэг СЕРЕНЬ дохионы төхөөрөмж суурилуулах | Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаар 15,9 сая төгрөг | Баруун-Урт сумын гамшгийн үеийн эрт зарлан мэдээлэх чадавх дээшилнэ | Баруун-Урт суманд 2 ширхэг байна | Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт 3 ширхэг СЕРЕНЬ дохио нэмж суурилуулах | Аймгийн хэмжээнд 2023-2024 оны өвөлжилт, хаваржилт хүндэрч аймгийн Онцгой Комиссоос зудын гамшигтай тэмцэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд гамшгаас хамгаалах сан болон Засаг даргын нөөц сан зарцуулагдаж дууссан. Үүнтэй холбогдуулан Монгол улсын Шадар сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гамшгийн үеийн эрт зарлан мэдээлэх 3 ширхэг СЕРЕНЬ дохио худалдан авах зардлыг шийдвэрлүүлэхээр аймгийн Засаг даргад ОБГ-ын даргын 2024 оны 32/369 тоот албан бичиг хүргүүлээд байна. | |
| 1.1.3 | Эрдэнэцагаан сум дахь гал түймэр унтраах, аврах 47 дугаар ангид гамшиг осолтой тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд туулах чадвар сайтай “Ланд-78” маркийн автомашин. | Улсын төсвөөс | Шуурхай албаны суудлын автомашин | - | Гамшиг осолтой тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа сайжирна. | Монгол Улсын Шадар Сайдын шийдвэр 2023 оны 12сарын 06 өдрийн 436 дугаар тогтоолоор Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах 47 дугаар ангид “Япон улсад үйлдвэрлэсэн Land-78” маркийн шуурхай албаны автомашин 2023 оны 12 дугаар сарын 29-ний өдөр олгосон. | |
| Стратегийн зорилт № 2. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх | | | | | | | |
| 1.2.1 | Монгол Улсын Шадар сайдын нэрэмжит гамшгаас хамгаалах команд штабын сургууль, бэлэн байдлын үзлэг зохион байгуулах | Орон нутгийн төсвөөс | Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулсан тоогоор | 2023 онд Халзан, Баяндэлгэр суманд гамшгаас хамгаалах команд штабын сургууль, Эрдэнэцагаан, Сүхбаатар, Асгат, Онгон, Уулбаян сумдад бэлэн байдлын үзлэг зохион байгуулсан. | Эрдэнэцагаан, Сүхбаатар, Асгат, Дарьганга сумууд бэлэн байдлын үзлэг, Мөнххаан, Баруун-Урт сум Гамшгаас хамгаалах команд штаб, Түмэнцогт суманд иж бүрэн сургууль, Сүхбаатар аймагт 2024 оны 10 дугаар сард команд штабын сургууль тус тус зохион байгуулна. | Аймгийн хэмжээнд 2023-2024 оны өвөлжилт, хаваржилт хүндэрч төмөр бүюу мөсөн зудын хэмжээнд хүрч нийт малын 44.8 хувь нь хорогдож, аймгийн Онцгой Комиссоос зудын гамшигтай тэмцэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд гамшгаас хамгаалах сан болон Засаг даргын нөөц сан зарцуулагдаж дууссан. Мөн Монгол Улсын Шадар сайдын баталсан хуваарь, төлөвлөгөөний дагуу 2024 оны 10 дугаар сард Гамшгаас хамгаалах Команд Штабын сургуулийг зохион байгуулахад санхүүгийн бэрхшээл болон орон нутгийн ээлжит сонгуулийн ажил 10 дугаар сард давхардаж байгаатай холбогдуулан аймгийн Засаг даргын зүгээс уг сургуулийг хийх боломжгүй шийдвэр гарсан. Уг нөхцөл байдлын харгалзан Онцгой байдлын ерөнхий газарт албан бичгээр хүсэлт хүргүүлсний дагуу 2025 оны 3 дугаар сард зохион байгуулахаар хойшлуулсан болно. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.2 | Монгол Улсын Шадар сайдын “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай 2016 оны 50 дугаар тушаалын хүрээнд Гамшгийн эрсдэлийг бууруулах өдөрлөг, нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах | Орон нутгийн төсвөөс | Гамшгийн үеийн удирдлага зохион байгуулалт хангагдана. | 2023 онд гамшгийн эрсдэлийг бууруулах өдөрлөг, арга хэмжээг 1 удаа зохион байгуулсан. | 2024 онд гамшгийн эрсдэлийг бууруулах өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулж, хамрагдах иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог идэвхжүүлэх | Монгол Улсын Шадар сайдын “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай 2016 оны 50 дугаар тушаалын хүрээнд Гамшгийн эрсдэлийг бууруулах өдөрлөг, нэгдсэн арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн. | - |
| 1.2.3 | Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг зохион байгуулах | Орон нутгийн төсвөөр | Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон бусдыг авран хамгаалах чадвахийг дээшлүүлнэ. | 2023 онд ангиллын сургалтыг 419 ААНБ-ыг хамруулан зохион байгуулсан | 2024 онд ангиллын сургалтыг 440 ААНБ-д зохион байгуулах | Төрийн болон нутгийн захиргааны байгууллага хуулийн этгээд- 107 удаа 111 цаг 2603 хүн<br>Удирдах бүрэлдэхүүн сургалт-5 удаа 6 цаг 175 хүн<br>Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги сургалт-4 удаа 5 цаг, 142 хүн<br>Иргэний сургалт-17 удаа 30 цаг, 1983 хүн<br>МСҮТ-н оюутан сурагчдын сургалт-3 удаа 3 цаг, 52 хүн<br>Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сургалт-51 удаа 45 цаг 3757 хүн<br>Сургуульд элсэхээс өмнөх насны сургалт- 29 удаа 15 цаг 1016 хүн<br>Ангиллын сургалтад нийт: 216 удаа, 215 цаг, 9728 хүн хамрагдсан байна. | |
| 1.2.4 | Монгол Улсын Шадар сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны, спортын сайдын хамтарсан 2019 оны 114/А/765 дугаар тушаалын хүрээнд “ Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг эрчимжүүлэх ажлын хүрээнд “Өсвөрийн аврагч-2024” аймгийн аварга шалгаруулах | Орон нутгийн төсвөөс | Өсвөрийн аврагч бүлгэмийн болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг аврах чадвахийг дээшлүүлнэ | “Өсвөрийн аврагч-2023” аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн “Өсвөрийн аврагч” 6 | “Өсвөрийн аврагч-2024” аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохиох | ОБЕГ, аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Монгол Улсын Шадар сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны, спортын сайдын хамтарсан 2019 оны 114/А/765 дугаар тушаалын хүрээнд “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг эрчимжүүлэх ажлын хүрээнд “Өсвөрийн аврагч-2024” тэмцээнийг 2 дугаар улиралд | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэмцээн зохион байгуулах | | | бүлгийн 48 сурагчдын дунд зохион явуулсан. | | төлөвлөсөн боловч, ОББ-ын 20 жилийн ойн арга хэмжээ 5 дугаар сард, УИХ-ын сонгууль 6 дугаар сард болж, бэлтгэл ажлыг хангуулахтай холбоотой уг тэмцээнийг 3 дугаар улиралд зохион байгуулахаар хойшлуулсан болно. | |
| 1.2.5 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хил залгаа аймаг болон орон нутгийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулах. | Үйл ажиллагааны зардлаар | Гамшиг, ослын үеийн хамтын ажиллагааг сайжруулах | 2023 онд тусгай чиг үүргийн болон хил залгаа 3 аймаг, 5 байгууллагатай хамтран ажиллах гэрээнд тодотгол хийж бэлэн байдлыг хангуулан ажиллав.. | 2024 онд Дорноговь, Хэнтий, Дорнод аймгуудтай хамтран ажиллах гэрээнд тодотгол хийнэ. Тусгай чиг үүргийн хилийн 2 анги, Зэвсэгт хүчин, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Авто тээвэр, Талын зам ОНӨҮГ, Цаг уур орчны шинжилгээний газруудын гэрээг тодотгоно. | Хэнтий, Дорнод, Дорноговь аймгуудтай харилцан ажиллах төлөвлөгөөг 2 жилийн хугацаатай байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>Мөн Зэвсэгт хүчний 338 анги, хилийн цэргийн 0146, 0184 дугээр анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газруудтай гамшгийн үед харилцан ажиллах төлөвлөгөөнд тодотгол хийж ажилласан. | |
| Стратегийн зорилго №2 ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА | | | | | | | |
| Стратегийн зорилт №3 Гамшгийн эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох, гамшиг судлалын шинжлэх ухаан, инновацыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх | | | | | | | |
| 2.1.1 | Аймгийн Онцгой Комисс, Шуурхай штабын үйл ажиллагааг шууд удирдлагаар хангаn зохион байгуулах. | Орон нутгийн төсөв | Гамшгийн үеийн удирдлага зохион байгуулалт хангагдана. | 2023 онд 12 удаа хуралдаж гамшиг, осол, цаг үеийн 37 асуудлыг тухай бүр шийдвэрлэн, шууд удирдлагаар хангаn зохион байгуулж ажилласан. | 2024 онд болзошгүй гамшиг, осол, цаг үеийн асуудлыг тухай бүр шийдвэрлэх, шууд удирдлагаар хангаn зохион байгуулж ажиллах. | 2023-2024 оны өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч мөсөн бүюу төмөр зудын хэмжээнд хүрсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын захирамжаар зудын гамшигтай тэмцэх, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий аймаг, сум бүрт Шуурхай штабыг байгуулж, 24 цагаар жижүүр томилон ажиллуулсан. Нөхцөл байдалтай уялдуулан АОК-ыг 7 удаа хуралдуулан аймгийн Засаг даргын 2024 оны А/04, А/198 тоот захирамжуудаар өндөржүүлсэн бэлэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдлын зэрэгт шилжүүлж, малчин өрхүүдэд тусламжийн багцууд хүргэх, зам гаргах, шар усны үерээс урьдчилан сэргийлж, эрсдэлтэй бүсэд байгаа 1063 өрхийг цаснаас гаргах, нүүлгэн шилжүүлэх, малын сэг зэм устгах зэрэг асуудлуудыг шат дараалан шийдвэрлэж ажилласан. | |
| 2.1.2 | МУЗГ-ын 2020 оны 189 дүгээр тогтоолоор батлагдсан Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, | Улсын төсвөөс | Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа сайжирна | 2023 онд үйл ажиллагааны хэрэгжилт 85.7%-тай хангагдсан. | 2024 онд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хэрэгжилтийг 90%-д хүргэнэ. | Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөнд 38 заалт бүхий 602,0 сая төгрөгийн гамшгийн эрсдэлийг бууруулах ажлыг төлөвлөж, аймгийн Засаг дарга, санхүү, төрийн сангийн хэлтсээр хянуулахаар хүргүүлж, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулахаар тогтоолын төслийг боловсруулаад байна. Эхний хагас жилийн байдлаар гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн хуралдаан хийгдээгүй болно. | |
| 2.1.3 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь заалтын дагуу Гамшгийн эрсдэлийн санд урьдчилан сэргийлэх аврах, хор уршгийг урилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний зохион байгуулалтын үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгийг тусгах. | Улсын төсвөөс | Гамшгийн эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаа дээшилнэ. | 2023 онд орон нутгийн гамшгийн эрсдэлийн сангаас 710,0 сая төгрөг зарцуулсан. | 2024 онд гамшгийн эрсдэлийн санд суулгах шаардлагатай 700,0 сая төгрөгийг батлуулж, шаардлагатай үйл ажиллагаанд зарцуулах | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2024 оны ээлжит хуралдаанаас гарсан 01 дүгээр тогтоолоор Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь заалтын дагуу Гамшгийн эрсдэлийн санд урьдчилан сэргийлэх аврах, хор уршгийг урилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний зохион байгуулалтын үйл ажиллагаанд зарцуулах 900.0 сая төгрөг батлуулсан. Үүнээс 2024 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал, зудын эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээнд зарцуулагдаж дууссан. | |
| 2.1.4 | Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 12 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах Газар хөдлөлтийн | Үйл ажиллагааны зардлаар | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Зөвлөлийн үйл ажиллагааны хэрэгжилт 80% хангагдсан | Зөвлөлийн үйл ажиллагааны хэрэгжилт 85%-д хүргэнэ | Газар хөдлөлтийн байнгын ажиллагаатай дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2024 оны 01 дүгээр сарын 26-ний өдрийн А/71 тоот | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байнгын ажиллагаатай дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн тодотгох, 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, хяналт тавьж ажиллах | | | | | захирамжаар шинэчлэн тодотгож, нийт 28 гишүүнтэйгээр байгуулан нийт 4 бүлгийн 15 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан эхний хагас жилээр биелэлтийг гарган ажилласан. | |
| 2.1.5 | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолын дагуу Сумд болон аж ахуйн нэгж, байгууллагад гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж, зөвлөмжийн дагуу эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах | Орон нутгийн төсөв | Эрсдэлийн үнэлгээ хийсэн тоогоор | 2 сум, 11 аж ахуйн нэгж байгууллагад гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийсэн | 2 сум, 16 аж ахуйн нэгж байгууллагад гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийнэ. | Аймгийн Засаг даргын 2024 оны А/108 дугаар захирамжаар гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулж, Зудын эрсдэлийн салбар дундын үнэлгээг 3 удаа, Шар усны үерийн салбар дундын үнэлгээг 1 удаа, Хээрийн түймрийн эрсдэлийн үнэлгээг 2 удаа, Үерийн эрсдэлийн үнэлгээг 1 удаа нийт 7 удаагийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж зөвлөмж боловсруулж, Улсын Онцгой Комиссын Шуурхай штаб, ОБЕГ-т хүргүүлж ажилласан. Эрсдэлийн үнэлгээнээс гарсан дүгнэлт, зөвлөмжийг аймгийн Онцгой Комисс, Шуурхай штабт танилцуулж, авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээг төлөвлөх, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэхэд дэмжлэг үзүүлж ажилласан. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум дахь хилийн Бичигт боомтод гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоотой хийж, 3 гамшгийн төрлөөр эрсдэлийн түвшинг үнэлж ажилласан. Мөн 16 аж ахуйн нэгж байгууллагад гамшгийн эрсдэлийн тухай ойлголт, эрсдэлийн үнэлгээ хийх заавар, дүрэм, журмын талаар сургалт зохион байгуулсан | |
| 2.1.6 | ОБЕГ-ын даргын баталсан 2021 оны А/255 дугаар тушаалын дагуу Аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаар гамшгийн | Аж ахуйн нэгж байгууллагын зардлаас | Гамшгаас хамгаалах чадавх дээшилнэ | 2023 онд 1 гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээнд анхан шатны | 2024 онд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий байгууллагын 7 тайланд анхан | ОБЕГ-ын даргын баталсан 2021 оны А/255 дугаар тушаалын дагуу Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний тусгай зөвшөөрөл бүхий 2 аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн гамшгийн эрсдэлийн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх, анхан шатны дүн шинжилгээ хийж, хяналт тавьж ажиллах | | | дүн шинжилгээ хийсэн | шатны дүн шинжилгээ хийх | нарийвчилсан үнэлгээний 3 тайланд анхан шатны дүн шинжилгээ хийж, хяналт тавьж байна. | |
| 2.1.7 | НҮБ-ийн Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилттэй “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төсөлтэй хамтран ажиллах. | Төслийн санхүүжилт | Орон нутагт төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах | 2023 онд 144 дүгээр салбарын агуулахын дээврийн их засвар, 016 дугаар цэгийг төвийн гэрэлтүүлэгт холбох ажлуудыг АДАПТ төслийн санхүүжилтээр гүйцэтгэсэн. | 2024 онд 144 дүгээр салбарын өвсний хашааг шинэчлэн барих ажлын зардлын тооцоог хүргүүлсэн. | Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ”Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 144 дүгээр салбарын өвсний хашаа, сарааны засварын ажлын хөрөнгө оруулалтыг тусгуулж, санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.<br>144 дүгээр салбарын өвсний хашаа, сарааг шинэчлэн, засварлах ажлыг батлагдсан төсвийн хүрээнд засварын ажлыг хугацаанд нь гүйцэтгэхээр ажиллаж байна. | |
| 2.1.8 | ЗГ-ын 339, 340 дүгээр тогтоолоор Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургууль, Газар хөдлөлтийг таниулах өдрийг зохион байгуулах. | Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас | Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг, ур чадвар сайжирна. | “Гамшгийн аюулын тухай” зарлан мэдээллийн дохиогоор 13 сумд, гамшгаас хамгаалах орон нутгийн 12 алба, 20 мэргэжлийн ангийн төлөөллийг хамруулан 8 удаа, 18 цаг, 216 хүнд танхимын сургалтыг зохион байгуулж ажиллалаа. | “Гамшгийн аюулын тухай” зарлан мэдээллийн дохиогоор ажиллах сургалт, дадлага сургуулийг зохион байгуулах ажлыг 13 сумд, гамшгаас хамгаалах орон нутгийн 12 алба, 20 мэргэжлийн анги, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, Сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдийг хамруулан 1200 хүнд танхимын сургалтыг зохион байгуулж ажиллана. | Гамшгийн аюулын тухай” зарлан мэдээллийн дохиогоор ажиллах сургалт, дадлага сургуулийг зохион байгуулах ажлыг 13 сумд, гамшгаас хамгаалах орон нутгийн 12 алба, 20 мэргэжлийн анги, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, Сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдийг хамруулан 837 хүнд танхимын сургалтыг зохион байгуулж ажиллана.<br>Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх “Зарлан мэдээлэл”-ийн дуут дохио дамжуулах нэгдсэн дадлага сургуульд 4492 иргэн хамрагдсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.9 | Аймгийн Онцгой комиссын гишүүд болон сумдын онцгой комиссын дарга нарыг сургалтад хамруулах | Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас | 13 суманд мэргэшсэн боловсон хүчин бэлтгэгдсэн байна. | 2023 онд аймгийн онцгой комиссын гишүүд болон сумдын онцгой комиссын гишүүдэд сургалт зохион байгуулсан. | Аймгийн болон Сумдын Онцгой комиссын гишүүдэд гамшгийн үеийн хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулна | ЗГ-ын 339, 340 дүгээр тогтоолоор батлагдсан Гамшгийн аюулын тухай" зарлан мэдээллийн дохиогоор ажиллах сургалт, дадлага сургуулийг 2024 оны 03 дугаар сарын 28-ны 16:00 цагт бүх шатны Засаг дарга, ЗДТГ-ын дарга нар 12 гамшгаас хамгаалах алба, 20 мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд зарлан мэдээлэх журам, газар хөдлөлтийн гамшгийг таниулах сургалт, мэдээлэл өгч, иргэдийг татан оролцуулж, 4492 хүнийг хамруулж ажилласан. | |
| Стратегийн зорилго №3 ГАМШИГТАЙ ТЭМЦЭХ, ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГАА | | | | | | | |
| Стратегийн зорилт №4 Гамшгийн нэгдсэн удирдлага зохицуулалтыг сайжруулах, холбоо, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах | | | | | | | |
| 3.1.1 | Гамшгийн үеийн бэлэн байдал, холбоо зохион байгуулах хээрийн дадлага сургуулийг зохион байгуулах | Улсын төсвөөс | Гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдал, чадавхи дээшилнэ. | 2023 онд хээрийн гаралтыг 2 удаа зохион байгуулсан. | 2024 онд бие бүрэлдэхүүний бэлэн байдал, холбооны тоног төхөөрөмжийн ашиглалтын хэвийн байдлыг хангаж, хүйтний болон дулааны улирлын хээрийн гаралт хийх | Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2008 оны 178, 179 дүгээр тушаал, 2011 оны Засгийн газрын 339, 340-р тогтоол, 2020 оны 10 сарын 26-ны № А/232, 233-р тушаал, 2017 оны Засгийн газрын 67-р тогтоол бусад холбогдох дүрэм журмуудыг үндэслэн Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын радио холбоо, зарлан мэдээллийн бэлэн байдал, мэдээллийн аюулгүй байдал зэргийг тус тус хангаж ажилласан. Зэвсэгт хүчний 338-р анги, Зэвсэгт хүчний 168-р тусгай роттой гамшгийн үед харилцан ажиллах үеийн холбоо харилцааны гэрээг боловсруулж батлуулав. Гэрээнд төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын утсан холбоо, цахим шуудан, радио холбооны үелзлүүдийг харилцан боловсруулж, холбоонд орон ажиллаж байна. | |
| 3.1.2 | Орон нутагт үүссэн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, гал түймрийн голомтод шуурхай арга хэмжээ | Улсын төсвөөс | Аюулт үзэгдэл, ослын тоогоор | 2023 онд гамшиг, осол, гал түймэр болон бусад төрлийн нийт | Гамшиг, осол, гал түймэр гарсан тухай бүрд мэргэжлийн удирдлага зохион | 2024 оны хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд гамшиг, осол, гал түймэр болон бусад төрлийн нийт 84 удаагийн мэдээ, мэдээллийг хүлээн авч гамшгийн голомтод шуурхай арга | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах. | | | 403 удаагийн мэдээ, мэдээллийг хүлээн авч ажилласан. | байгууллалтаар шуурхай хангаж ажиллах анги салбар | хэмжүүэ авч мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан. | |
| 3.1.3 | “Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журам”, “Уснаас эрэн хайх,аврах ажиллагаа зохион байгуулах журам”-ын хэрэгжилтыг хангах хүрээнд Уснаас Эрэн хайх, аврах ажиллагааны хамтарсан дадлага сургууль зохион байгуулах. | Улсын төсвөөс | Алба хаагчдын мэдлэг, ур чадвар сайжирна. | 2023 онд Урсгал уснаас эрэн хайх, аврах ажиллагааны дадлага сургуулийг Зүүн бүсийн төв Дорнод аймгийн ОБГ-тай хамтран зохион байгуулсан. | Хэнтий аймгийн Онцгой байдлын газартай хамтран Баян-Овоо сумын “Гүрмийн нуурны сургалтын төв”-д уснаас эрэн хайх, аврах ажиллагааны дадлага сургууль хийх. | Хэнтий аймгийн Онцгой байдлын газартай хамтран Баян-Овоо сумын “Гүрмийн нуурын сургалтын төв”-д уснаас эрэн хайх, аврах ажиллагааны дадлага сургуулийг 3-р улиралд хийхээр төлөвлөөд байна. | - |
| Стратегийн зорилго №4 ГАМШИГ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ УЛСЫН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ | | | | | | | |
| Стратегийн зорилт №5 Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулах | | | | | | | |
| 4.1.1 | МУ-ын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хянах. | Хөрөнгө шаардлагагүй | Гамшгаас хамгаалах бэлэн байдал хангагдана. | 2023 оны зорилтын хэрэгжилтийг хангаж 40 аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хянаж, тодотгол хийх | Онцгой байдлын газрын 2024 оны зорилтын хэрэгжилтийг хангаж 40 аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хянаж, тодотгол хийх | 2024 оны эхний хагас жилийн байдлаар МУ-ын Шалар Сайдын 120 дугаар тушаалын хүрээнд 18 аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хянаж, тодотгол хийсэн. | |
| 4.1.2 | - ОБЕГ-ын даргын 2023 оны А/288 тоот тушаалын 5-р хавсралтаар Барилгын зураг төслийг хянах,<br>- МУЗГ-ын 2021 оны 212 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын захирамаар барилга байгууламжийг ашиглалтанд оруулах | Хөрөнгө шаардлагагүй | Барилгын зургийн төсөл хянах. Улсын комисст ажиллах ажлын байрны дүгнэлт зэргийг дүрэм | Улсын комиссын бүрэлдэхүүнд 23 удаа ажиллаж, иргэн хуулийн этгээдийн барилгын 30 зураг төслийг хянаж, ажлын | Улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллаж барилгын зураг төслийг хянаж, ажлын байрны дүгнэлт олгож ажиллах. | Сүхбаатар сумын 2 дугаар баг 10/04кв-ын 400кВА гадна цахилгааны дэд станц, 6300м2 баяр наадмын талбай, Асгат сумын 4 дүгээр баг 3 давхар 1186 м2 ерөнхий боловсролын сургуулийн их засвар, 35/10кв-ын гадна цахилгааны дэд станц, Халзан сумын 1 дүгээр баг явган хүний замын барилгын ажил, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллах,<br>- МУШС-ын 2023 оны дугаар 75 тоот Галын аюулгүй байдлын дүгнэлт олгох журмын дагуу ажлын байрны дүгнэлт олгох | | журмын дагуу шийдвэрлэх | байрны 162 дүгнэлт олгосон. | | Баруун-Урт сум 8 дугаар баг Мал эмнэлгийн хяналт, халдваргүйтгэлийн цэгийн барилгын ажил, Эрдэнэцагаан сум 7-р баг Ус цаг уурын өртөөний барилгын засварын ажлын зураг, Уулбаян сум 2-р баг 15/04 кв 160 кВА дуд станц, 0.4 кВ-ын ЦДШ наадмын талбайн цахилгааны ажлын зураг, Сүхбаатар сум 5-р баг Талын гал уурхайн ажилчдын байрны цогцолборын зураг, Цэвэр бохир шугамын зураг, Дарьганга сум 2-р баг 15/04 кв 160 кВА дуд станц, 0.4 кВ-ын ЦДШ Аялал жуулчлалын цогцолбор газрын гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төслийг хянаж дүгнэлт гарган 950.000 мянган төгрөгийг аймгийн төрийн сангийн дансанд төвлөрүүлж ажилласан.<br>Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/103 тоот захирамж, 02 дугаар сарын 27-ний өдрийн А/125 тоот захирамж, 05 дугаар сарын 08-ны өдрийн А/271 тоот захирамж, 05 дугаар сарын 08-ны өдрийн А/276 тоот захирамж, 05 дугаар сарын 21-ний өдрийн А/300 тоот захирамж, 05 дугаар сарын 22-ны өдрийн А/301 тоот захирамж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн А/47 тоот “Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх, ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах журмын 3 дугаар хавсралтын дагуу Баруун-Урт сумын 7 дугаар баг Баян шарга өргөө хотхон, 960 хүүхдийн сургууль, Шинэ тэмүүлэл хотхоны 1 дүгээр ээлж, Хос-Өргөө орон сууцны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1 дүгээр ээлж, Спорт цогцолбор, Наран сум 0.4 кВ-ын шугамын өргөтгөл, дэд станцын шинэчлэлийн ажил, Дарьганга зусланг орчин үеийн стандарт нийцсэн амралт, аялал жуулчлалын цогцолбор болгон шинэчлэх гадна инженерийн шугам сүлжээний барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах улсын комисст ажилласан. Галын аюулгүй байдлын шаардлага хангаж хүсэлт гаргасан 84 аж ахуйн нэгж байгууллагад галын аюулгүй байдлын дүгнэлт олгон 2.200.000 мянган төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлж, бусад аж ахуйн нэгж, байгууллагад хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажиллаж байна. | |
| 4.1.3 | Монгол Улсын Шадар сайд, ОБЕГ-ын дарга болон Онцгой байдлын газрын даргын баталсан нэгдсэн арга хэмжээний удирдамжийн дагуу гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулах | Улсын төсвөөс | Баттлагдсан удирдамжийн хүрээнд иргэн, аж ахуй нэгж байгууллагын галын аюулгүй байдлыг хангах | Нэгдсэн арга хэмжээний удирдамжийн хүрээнд гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулж 218 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалтыг зохион байгуулсан. | Нэгдсэн арга хэмжээний удирдамжийн хүрээнд 240 аж ахуйн нэгж, байгууллагад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулах | Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “Орон сууцны зоорины болон 1-р давхарт шингэрүүлсэн шатдаг хий ашиглан үйл ажиллагаа явуулдаг иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжид, “Сендвич хавтан, тавилга, вакум цонх, бетон зуурмагийн үйлдвэр”, “Шатахуун түгээх станц /ШТС/, Автомашин хийгээр цэнэглэх станц /АХЦС/, Хий цэнэглэх станц /ХЦС/”-ын, Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, “Зочид буудал, дэн буудлын барилга байгууламж, Амралтын газар, жуулчны бааз, хүүхдийн зуслангийн барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу Сүхбаатар аймгийн Онцгой байдлын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад М.Дамба, дэслэгч А.Галсандорж, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцааг ахлах дэслэгч С.Батхуяг нар Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Эрдэнэцагаан суманд үйл ажиллагаа явуулж буй орон сууцны зоорины болон 1-р давхарт шингэрүүлсэн шатдаг хий ашигладаг аж ахуйн нэгж, “Сендвич хавтан, тавилга, вакум цонх, бетон зуурмагийн үйлдвэр”, “Шатахуун түгээх станц /ШТС/, Автомашин хийгээр цэнэглэх станц /АХЦС/, Хий цэнэглэх станц /ХЦС/”, Эрүүл мэндийн байгууллага, “Зочид буудал, дэн буудал, “Амралтын газар, жуулчны бааз, хүүхдийн зуслангийн барилга байгууламжид төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийн хооронд зохион явуулж ажиллалаа. | |
| 4.1.4 | Монгол Улсын Шадар сайдын баталсан нэгдсэн арга хэмжээний удирдамж, хүрээнд Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах. | Орон нутгийн төсвөөс | Орон нутгийн хэмжээнд зохион байгуулан иргэдэд гамшиг ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг өгөх | 2023 онд гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ 7 удаа зохион байгуулсан. | 2024 онд гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ 7 удаа зохион байгуулна. | “Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдал” нэгдсэн арга хэмжээний удирдамжийн хүрээнд Онцгой байдлын газар, аймгийн Засаг даргын Тамгын газар, “Хүүхэд, Гэр бүл хөгжил хамгааллын газар, “ДБЭХС,ТӨХК” хамтран удирдамж боловсруулан 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 04 дүгээр сарын 30-ны хүртэлх хугацаанд 13 сумын гэр хорооллын 1827 айл өрхэд галын аюулгүй байдал, стандарт, норм, нормативыг сурталчлан таниулсан агуулга бүхий 3 төрлийн 3200 гаруй сурталчилгааны гарын авлага зөвлөмж, сэрэмжлүүлгийг тараах, ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулан нийт 11069 иргэнд гал түймрийн аюулаас урьдчилан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сэргийлэх мэдээ, мэдээллийг хүргэж ажилласан. “Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлье” удирдамж”-ийн хүрээнд 16 заалттай төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргын 2024 оны А/108 тоот захирамжаар ажлын хэсэг томилогдон аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үүсэх Шар усны үерийн эрсдэлийн салбар дундын үнэлгээ хийж шар усны үерт өртөж болзошгүй 1065 өрхийн судалгааг гаргасан. Онцгой байдлын байгууллагаас шар усны үерт өртөж болзошгүй 37 өрхийг нүүлгэн, сумдын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангитай хамтран 183 өрхийг цаснаас гарган ажилласан.Баруун-Урт сумын төвийн 2,5 км урттай үерийн далан, шуудуу, авто замуудын ус зайлуулах хоолойн хог, лаг шавар, хуримтлагдсан хайрга, шороог цэвэрлэж ус урсан гарахад саадгүй болгосон.Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааг зохион байгуулж хүн ам олноор цуглардаг зах, худалдааны төв, үйлчилгээний газруудад санамж, сэрэмжлүүлэх мэдээллийг 6 удаа, багц мессежийг 4 удаа дамжуулж давхардсан тоогоор 15400 иргэнд хүргэсэн. Газар хөдлөлтийн аюцлаас урьдчидан сэргийлье” Гамшгийн аюулын тухай” зарлан мэдээллийн дохиогоор ажиллах сургалт, дадлага сургуулийг зохион байгуулах ажлыг 13 сумд, гамшгаас хамгаалах орон нутгийн 12 алба, 20 мэргэжлийн анги, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, Сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдийг хамруулан 837 хүнд танхимын сургалтыг зохион | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулж ажиллана.<br>Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх “Зарлан мэдээлэл”-ийн дуут дохио дамжуулах нэгдсэн дадлага сургуульд 4492 иргэн хамрагдсан.<br>“Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хээрийн түймрийн эрсдэл өндөртэй Сүхбаатар, Эрдэнэцагаан, Дарьганга, Асгат сумдад "ИРГЭН БҮРИЙН ОРОЛЦОО ЭРСДЭЛИЙГ ДАВАХ ХҮЧ" уриан дор хээрийн тйүмрээс урьдчилан сэргийлэх өдөрлөг арга хэмжээг зохион байгуулан аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагч, иргэдэд “Гамшгаас хамгаалах хууль”, “Галын аюулгүй байдлын хууль” холбогдох хууль тогтоомжийн хүрэнд сургалт зохион байгуулж мэдээлэл хүргэн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажилласан. Мөн Онцгой байдлын газраас 4 сумын Засаг даргын Тамгын газарт хээрийн түймэртэй тэмцэх чадавхыг сайжруулах зорилгоор тус бүр 2 ширхэг /нийт 8 ширхэг/ үлдээгч аппаратыг хүлээлгэн өгсөн. | |
| Стратегийн зорилт №6 Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлж, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулах | | | | | | | | |
| 4.2.1 | Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/135 тоот тушаал “Гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага, сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал, зааврын”-ын дагуу зохион байгуулах. | Улсын төсвөөс | Аж ахуйн нэгж байгууллагын ажилтан алба хаагчид гал түймрийн үед анхан шатны багаж хэрэгсэл хэрэглэх, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах | 2023 онд 88 аж ахуйн нэгж, байгууллагад Гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага, сургалтыг зохион байгуулсан. | 2024 онд 92 аж ахуйн нэгж, байгууллагад Гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага, сургалтыг зохион байгуулж, гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө, карт боловсруулж тодотгол хийх. | Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/135 тоот тушаал “Гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага, сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал, зааврын”-ын дагуу 2024 оны хагас жилд тактикийн дадлага сургалт удаа 3, тархалтыг дадлага сургалтыг 41 удаа нийт 44 аж ахуйн нэгж байгууллагад, Урьдчилан сэргийлэх тасагтай хамтран хичээл сургалтыг танхимаар болон дадлагаар зохион байгуулж ажилласан. Сургалтад аж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | чадавх дээшилнэ. | | | ахуйн нэгж, байгууллага 360 хүн хамрагдсан. Онцгой байдлын албанаас давхардсан тоогоор 305 алба хаагч, 51 техник хэрэгсэл оролцсон. | |
| 4.2.2 | Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны А/188 тоот тушаалын 2 дугаар хавсралт. Өдөр тутмын дасгал сургуулийг батлагдсан төлөвлөгөө, гал түймэр унтраах, аврах ангийн цагийн хуваарийн дагуу зохион байгуулах | Хөрөнгө шаардлагагүй | Алба хаагчдын мэргэжлийн ур чадвар сайжирна. | 2023 онд 730 удаа сургалт дадлагыг зохион байгуулж алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг сайжруулсан. | 2024 онд Батлагдсан төлөвлөгөөний дагуу өдөр тутмын дадлага сургалтыг 729 удаа зохион байгуулах. | 2024 онд Батлагдсан төлөвлөгөөний дагуу өдөр тутмын дадлага сургалтыг хагас жилд 334 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 2004 алба хаагч 3006 цагийн сургалтад хамрагдсан. | |
| 4.2.3 | “Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журам”, “Өндрөөс аврах ажиллагаа зохион байгуулах заавар”-ын хэрэгжилтыг хангах хүрээнд Эрэн хайх, аврах ажиллагааны болон гамшиг ослоос урьдчилан сэргийлэх дадлага, сургалт зохион байгуулах. | Улсын төсвөөс | Алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг сайжирна | 2023 онд сургалт дадлагыг 3 удаа зохион байгуулж алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг сайжруулсан. | 2024 онд Батлагдсан төлөвлөгөөний дагуу дадлага сургалтыг сард 1 удаа нийт-14 удаа зохион байгуулах. | Эрэн хайх, аврах салбарын алба хаагчид хамтран 17 аж ахуй нэгжид Эрэн хайх, аврах ажиллагааны болон гамшиг ослоос урьдчилан сэргийлэх дадлага, сургалтыг давхардсан тоогоор 248 ажилтан, алба хаагчийг хамруулан зохион байгуулсан. Тус байгууллагын онцлог, барилгын хийц бүтэц, байршил, тэсэрч, дэлбэрэх аюулын зэрэглэл, усан хангамж, авралтын зам гарц, ажилтан алба хаагчдын судалгаа гаргаж авсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.4 | Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/157 дугаар тушаалаар батлагдсан ОБАЭБ-ын “Тээврийн хэрэгсэл ашиглах журам гал унтраах үндсэн албаны болон туслах албаны, шуурхай албаны автомашинуудад “Тээврийн хэрэгсэл ашиглах журам”-ын хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагааны зардал | Тээврийн хэрэгсэл ашиглах журмыг хангаж ажиллах. | Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/157 дугаар тушаалаар батлагдсан ОБАЭБ-ын “Тээврийн хэрэгсэл ашиглах журам”-ын хэрэгжилтийг 90 хувьтай хангаж ажилласан | Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/157 дугаар тушаалаар батлагдсан ОБАЭБ-ын “Тээврийн хэрэгсэл ашиглах журам”-ын хэрэгжилтийг 100 хувьд хүргэж ажиллах. | Зудын гамшигтай тэмцэх, хор уршиг хохирлыг арилгах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тус газар шуурхай албаны Ланд 76, 78 автомашин Ковш дугуйт ачигч Зил 131 зэрэг 4 нэгж техникийг хүлээн авч бүртгэлжүүлсэн. Цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас аврах ажиллагааны дуудлага ихсэж, малчдад өвс тэжээл, түлээ нүүрс хүргэхэд зам гаргах болон эрэн хайх, аврах ажиллагаанд байнгын дуудлага үйлчилгээ үзүүлэх үед автомашин техникийн эвдрэл гэмтэл их гарч нэн шаардлагатай байгаа сэлбэг хэрэгслийн тооцоо гаргаж танилцуулж нийт 13,013,000 төгрөгийн сэлбэг запас шийдвэрлүүлж ажилласан. Мөн Японы хүүхдийн сангаас хандив тусламжаар өгсөн Ланд круйзер автомашины 10ш дугуй хүлээж авсан.<br>Техникийн шаардлага хангахгүй, ашиглах боломжгүй 6-н автомашиныг 2024 оны эхний улиралд актлуулахаар ОБЕГ-ын өмч хамгаалах зөвлөлд санал хүргүүлсэн. Онцгой байдлын газрын даргын зөвлөлийн хурлаар шуурхай албаны автомашинд нэн шаардлагатай байгаа сэлбэг хэрэгслийн судалгааг гаргаж танилцуулж шийдвэрлүүлсэн. | |
